

**ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЭРДЭНЭЧИМЭГИЙН НАРАНГЭРЭЛИЙН
2025 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
<p align="center">Зорилт 1. Соёл, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлан мэдээлэх.</p>								
1.	Арга хэмжээ 1.1. Төрийн шагналаар шагнуулах иргэдийн материалыг журмын дагуу хянах, төрийн дээд шагналын программд тухай бүр шивэж оруулах.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо -	-	2	2024 онд хүлээн авсан материалыг хариуцан авсан. Шаардлага хангаагүй дууту материалыг буцаан дахин бүрдүүлэлт хийлгэж өгсөн. Шагналд тодорхойлуулсан хүмүүсийн анкетыг эксэл файл дээр тус бүр нэгтгэн шивэж бүртгэн, материалыг сканнардаж албан мэйлээр явуулсан. Мөн шагналд тодорхойлох зөвлөл хуралдаж хурлын тэмдэглэлийг хөтлөн явуулж, Засаг даргын тоотыг гаргуулан болзол хангасан 139 иргэн, нөхөн олгохоор тодорхойлуулсан 2 иргэний материалыг нийт 4 удаагийн давтамжтай Өвөрхангай аймгийн шагнал хариуцан авсан мэргэжилтэнтэй холбогдон хүлээлгэн өгсөн.	01.15-12.01	100	

2	<p>Арга хэмжээ 1.2. Жуулчинд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг бүртгэж соёл, аялал жуулчлалын судалгаа, статистик мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэх</p>	<p>Бүртгэсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо</p>	-	2	<p>2025 оны байдлаар Хархорин суманд байршилтай Жуулчны бааз-25, зочид буудал-8, зоогийн газар, ресторан-13 мэдээллийн санг шинэчлэн, ариун цэврийн байгууламж, орны тоо, жуулчдыг хүлээн авах хүчин чадал, хоол ундааны төрөл, үйлчилгээний давуу тал зэргийг судлан хяналтыг хийж гүйцэтгэлээ. Хархорин сумын зуны улиралд жуулчдыг хүлээн авах хүчин чадлыг дээрх судалгааны дагуу 3200 гэж тооцооллоо.</p> <p>Жуулчдын тоон үзүүлэлт сүүлийн 2025 оны 3-р улирлын байдлаар гадаад - 35409, дотоод – 42310, нийт 77719 жуулчин Хархорин суманд зочилсон үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оны 4-р улирлын жуулчны тооноос 6000-р зөрөг нөлөөг тодорхой харуулж байна.</p>	05.01-12.01	100%
3.	<p>Арга хэмжээ 1.3. Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд орчны бохирдол, хог</p>	<p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо</p>	-	2	<p>Эрдэнэзуу музейгээс цааш Зүүн найман төгөл хүртэлх Түркийн замын хог хаагдлыг цэвэрлэсэн.</p>	04.01-11.01	100

	ХАЯГДЛЫН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛГЭ АЖИЛЛАХ				<p>Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдрийг тохиолдуулан эхний хагас жил Сайрын 1-4 хүртэлх гудмуудын айл өрхүүдэд шаардлага тавьж цэвэрлэгээг хийлгэж, хариуцан ажигласан. Хөгшин Орхон голын ай сав газрыг цэвэрлэх ажлын хүрээнд Орхон голын эхээс Хашаат сумын хилийн зааг хүртэл нийт 40 км газарт тархсан хог хаягдыг цэвэрлэх ажилд сумын 20 төрийн байгууллагын нийт 300 гаруй албан хаагчид оролцож, 18 тонн хог хаягдыг цуглуулж, сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн. Хот тохижилтын алба сумын аялал жуулчлалын гудамж, Эрдэнэ зуугийн гудамжны хог хаягдыг цаг тухай бүрт нь цэвэрлэж, засмал замын хогийг шүүрдэж, зам дэд бүтцийн сайжруулалт хийгдсээр байна. Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдрийг тохиолдуулан сүүлийн хагас жилд Манлай тод зах, Ойдов жуулчны бааз, Соёмбо хорооллын гудмуудын айл өрхүүдэд шаардлага тавьж</p>		

				Цэвэрлэгээг хийлгэж, хариуцан ажигласан.			
Зорилт 2. Соёл, аялал жуулчлал, олон нийтийн арга хэмжээг хариуцан зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын сонирхлыг татах урлаг, соёл, спорт, бизнесийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн, үр дүнг тооцох.							
1.	Арга хэмжээ 2.1. Сумын баяр наадам зохион байгуулахад оролцох	Арга хэмжээний тоо	-	1	Хархорин сум байгуулагдсаны 69 жилийн үндэсний ойн баяр наадмыг зохион байгуулж, баяр наадмын самбар хийж, нээлтийн жагсаалд нийт 35 байгууллагыг амжилттай хамруулан оролцуулгаа. Мөн сумын 70 жилийн ойн киноны зураг авалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үйл ажиглалааг амжилттай хэрэгжүүлэв.	07.09-10	100
2.	Арга хэмжээ 2.2. "Торгоны зам-Хархорум хот" соёл, аялал жуулчлалын фестивалийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиглах	Жуулчдын тоо	-	4500	2025 онд зохион байгуулагдаагүй.	08	
3.	Арга хэмжээ 2.3. Уламжлалт идээ, ундааны фестиваль зохион байгуулах	-Уламжлалт хоол, идээ ундааны төрөл зүйл, хамрагдсан	-	5	"Хархоринь намар - 2025" үзэсгэлэн худалдаа хоёр өдрийн турш, оролцогч үйлдвэрлэгчид, үйлчлүүлэгчдийн дунд	09.25-26	100

	<p>ХҮНИЙ ТОО, -ЗОХИОН Байгуулсан арга ХЭМЖЭЭНИЙ ТОО</p>			<p>амжилттай Байгуулагдсан. Тус арга хэмжээ нь орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, хөдөө аж ахуйн салбарын уламжлал, шинэчлэл, бодит үр дүнг харуулах зорилготойгоор зохион байгуулагддаг уламжлалт арга хэмжээ юм. Энэ жилийн үзэсгэлэн худалдаанд:</p> <ul style="list-style-type: none"> • 5 хоршоо, • 46 иргэн, үйлдвэрлэгч • 121 нэр төрлийн <p>бүтээгдэхүүнээр оролцож, нийт 21.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онуудын үзүүлэлттэй харьцуулахад өсөлттэй дүн боллоо.</p> <p>Арга хэмжээний үеэр иргэд, оролцогчдын идэвх санаачилга нэмэгдэж, орон нутгийн үйлдвэрлэлийн хөгжилд зөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд цаашид үзэсгэлэн худалдааг өргөжүүлэн зохион байгуулах нөхцөл болгож бүрдэж байна.</p>		
--	---	--	--	---	--	--

					<p>Үзэсгэлэн худалдааны үеэр "Orel pic", "Дэмбээ", "Жин таах", "Гүтэй айлын гүзээтэй хүү" зэрэг сонирхолтой арга хэмжээ зохион байгуулагдаж, иргэддээ баяр баясал нэмж зохион байгуулагдсан.</p> <p>Сүү, сүүн бүтээгдэхүүний төрөлд нийт 12 иргэн, ААН оролцож 10 төрлийн идээ, ундааны төрлөөр 100 гаруй бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцсон.</p> <p>Сүү, сүүн бүтээгдэхүүн - Жалбаа багийн иргэн С.Энхцэцэг даргатай "Уржин дэлгэр өвөр элстэй" хоршоо шалгарсан.</p>		
4.	<p>Арга хэмжээ 2.4. Хархорин марафон гүйлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох</p>	<p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо</p>	-	1	<p>Хархорин марафон 2025 "Гүйж сурья" арга хэмжээнд ЗДТГ-ийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор 02 дугаар сарын өглөөний гүйлтийн хуваарь гарган ирцийг бүртгэх ажлыг эхлүүлсэн. Хархорин марафон нь 2025 онд нийт 5 төрөл, 9 ангилалтай бөгөөд энэ жил марафоны ажлын хэсэгт орж захирамжийг багтуулан нийт постер болон бичлэгэн мэдээ 6 хийж,</p>	06.14	100

					Хархорин мэдээ болон арга хэмжээний цонх, идэвхжүүлэх самбарыг бэлтгэсэн байна. Бэлтгэл ажил үргэлжлэн марафонд оролцогчдийн бүртгэлийг хийж байна. 21 км 097 метрийн гүйлт 18+ нас (эрэгтэй эмэгтэй), 10000 метрийн гүйлт 18+ нас (эрэгтэй эмэгтэй), 5000 метрийн гүйлт 12-17 нас, 18-34 нас, 35-54 нас, 55+ нас (эрэгтэй, эмэгтэй), 1500 метрийн гүйлт (Гэр бүл), 800 метрийн 18+ нас ХБИ=тэргэнцэртэй иргэд гэсэн 5 төрөлд, 9 ангиллаар зохион явууллаа. Арга хэмжээнд 15 байгууллагын 275, Баян-Өлзий, Бүлган, Эрдэнэт, Улаанбаатар хотын 29 тамирчин тус тус оролцсон.		
5.	Арга хэмжээ 2.5. Миний нутаг сайхан 2025 урлаг, спортын наадмыг зохион байгуулахад оролцох	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	1	"Миний нутаг сайхан" Урлаг, Спортын наадам-2025 тэмцээнийг 11 дүгээр сарын 07-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Спортын төрөлд 360 гаруй, урлагийн төрөлд 150 гаруй, нийт 152 аж ахуйн нэгж байгууллагын 660 гаруй албан	11.07-15	100

					хаагч оролцлоо. Урлаг, спортын 6,6 төрөлтэй явагдсан бөгөөд нэгдсэн дүнгээр 1 дүгээр байрт Засаг даргын Тамгын газраар ахлуулсан баг, 2 дугаар байрт ШШГХэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиар ахлуулсан баг, 3 дугаар байрт ерөнхий боловсролын Гүнзгий сургуулиар ахлуулсан баг тус тус шалгарлаа.		
6.	Арга хэмжээ 2.6. Монгол бичгийн уралдаан зохион байгуулах, ЕБС-ийн багш нартай хамтран сургалт зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	Хархорин сумын Хэлний бодлогын зөвлөлгөөс санаачлан уламжлалт өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг дэмжих зорилгоор "Монгол бахархал" аяны хүрээнд Монгол бичгийн олимпиадыг 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Олимпиадын хүрээнд удирдамжийг боловсруулж батлуулах, оролцогчдын мандатыг хэвлэн 4 сургуульд тараах, тэмцээний явцад хяналт тавих зэрэг зохион байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.	11.19-20	100	

7.	Арга хэмжээ 2.7. Угийн бичиг хөтлөн явуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Арга хэмжээ	-	1	Тус олимпиадад ерөнхий боловсролын дөрвөн сургуулийн 225 сурагч, монгол бичиг сонирхогч 35 иргэн оролцож, мэдлэг ур чадвараа сорин өрсөлдсөн нь "Монгол бичиг"-ийн хэрэглээ, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа. Хэлний бодлогын зөвлөлөөс санаачлан зөвлөлийн гишүүн Ш.Амарбат мэргэжлийн багш нарт монгол бичгийн сургалт явуулав. Эвхмэл бичгээр уран бичих онцлог, компьютерт эвхэж бичих анхан шатны чадвар олгох сургалт зохион байгууллаа. Нийт төрийн байгууллага-27, албан хаагчдын тоо – 450 монгол бичгийн анхан, дунд шатны сургалт, сорилтд хамрагдав.	Нэг өрх – Нэг угийн бичиг аяны хүрээнд Соёлын төвд угийн бичгийн булан тохижуулах: Угийн бичгийн ажлын хэсэг хуралдаж сумын угийн бичиг судлах танхимыг Соёлын төвийн номын сангийн буланг тохижуулахаар болсон. Уг-	02.10-03.25	100

					<p>Булганг 2-р сургуулийн зургийн дуугуйтангын сурагчидтай хамтран Ургийн мод зурж, Соёл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн мэдээллийн самбар хийсэн. Мөн буланд Соёлын төвийн номын санч ширээ сандгаар тохижуулалт хийсэн.</p> <p>Угийн бичгийн үзэсгэлэн гаргах: Ерөнхий болговсролын сургуулийн номын санч нартай хамтран 4 сургууль дээр өртөөчилсэн хэлбэрээр угийн бичгийн үзэсгэлэн гаргасан. Уг үзэсгэлэнд нийт 24 бүтээлүүдийг оролцуулав.</p> <p>Угийн бичгийн аяны хүрээнд зарласан эсээг шалгаруулах: Ерөнхий болговсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд Угийн бичиг-Удмын түүх сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зарласан. 4 сургуулийн нийт 16 сурагч эсээгээ ирүүлсэн байна. Сонгон шалгаруулалтыг Соёлын төвийн эрхлэгч, Номын санч, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нартай хамтран удирдамжийн</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>Шаардлагад нийцүүлэн дүгнэж 1-р байрыг Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 9 а ангийн сурагч Т.Сайнсаран 2-р байрыг Угсын тэргүүний Орхон сургуулийн 9в ангийн сурагч А.Анужин 3-р байрыг Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 106 ангийн сурагч Б.Ану нар тус тус эзэлсэн байна.</p> <p>Нэг өрх- Нэг угийн бичиг 2 аяны хүрээнд Өвөрхангай аймагт болсон тайлант үзэсгэлэнд Хархорин сум Тусгай байр эзэлсэн.</p> <p>Шинээр угийн бичиг хөтлөлтийг насан туршийн боловсролын төвийн арга зүйч болон Ерөнхий боловсролын сургуулийн номын санч нар нийт 1200 өрхөд сургалт хийж, хөтлүүлж шинээр 260 өрхийг шинээр угийн бичиг хөтлүүлсэн байна.</p>		
8.	Арга хэмжээ 2.8. Нутгийн иргэдийн үйлдвэрлэлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох,	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийн тоо	-	3	Шанх Багийн иргэн Ц.Хишигтийн гэр бүл цагаан идээг боловсронгуй болгон нэмэлт орлоготой болох хүсэлтэй байсан бөгөөд	04.08.06.06	100

	Тэднийг нэмэлт орлогой болгох, хамтран ажиллах					Тараган бялуу, Шар сүүний цэлцэгнүүр, Шар сүүний хатаамал гэх мэд эдгээр бүтээгдэхүүний орц найрлага, хадгалах хугацаа зэргийг оруулсан бүтээгдэхүүний шошгоны загварыг гарган нийт 300 ширхэгийг малчдын фото цаасаар хэвлэн гарган өгсөн.		
9.	Арга хэмжээ 2.9. Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд Засаг даргын ивээл дор зохион байгуулах	Хамрагдсан залуучуудын тоо	-	100	Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан Хархорин суманд "Иргэний андгай өргөх ёслол"-ыг ёслол төгөлдөр зохион байгууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд 16 нас хүрч, иргэний үнэмлэхээ гардан авч буй 66 суралч оролцож, Монгол Улсын иргэний эрх, үүргээ дээдлэн биелүүлэхээ андгайлан тангараглав.	11.26	100	
Зорилт 3. Соёлын биет, болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, сургалт, сурталчилгааг зохион байгуулах.								
1.	Арга хэмжээ 3.1. "Бүх нийтийн соёлын болговсрол" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөгөө	-	1	Эрдэнэ Зуу музей, ДӨ-ОХСДГХ-н захираагтай хамтран Олон улсын музейн өдрийг тохиолдуулан, Эрдэнэ Зуу	06.09-06.13	100	

<p>замаар аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах сургалт зохион байгуулах</p>				<p>Музейн 60 жилийн ойг утган "GUIDES-11" сургалтыг амжилттай зохион байгууллаа. Үүнд Аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч бэлтгэдэг сургалтын төв болон Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч жуулчны тур операторуудын хөтөч тайлбарлагч нар нийт 64 хүн хамрагдан оролцлоо.</p>		
<p>2. Арга хэмжээ 3.2. Өндөр Гэгээн Занабазарын түүхт 390 жилийн ойт тохиолдуулан хүүхэд, залуучуудад түүхэн хүмүүний намтар түүх, соёлын өвийг сурталчлан түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Арга хэмжээ</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>Анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын мэндэлсний 390 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ойг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/211 дугаар захирамжийн дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сумаас төлөвлөгөөнд тусгах саналыг хүргүүлсэн.</p> <p>"Өндөр Гэгээнийхээ өвийг дээдэлэн өнөд эгшиглэн хуураа хөглье" сэдэвт арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уг үйл ажиллагаанд:</p> <ul style="list-style-type: none"> • Соёлын төв • Эрдэнэ зуу музей 	<p>02.18-11.30</p>	<p>100</p>

				<ul style="list-style-type: none"> • Хархорин музей • Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгал газрын • Хамгаалалтын захиргааны соёлын мэргэжилтэн нар хамтран ажиглаж, сургалт, Өндөр Гэгээний туурьвасан фото зургийн үзэсгэлэн, номын үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Уг үйл ажиглалгааны хүрээнд Ерөнхий болговсролын сургуулийн 300 гаруй сурагчид идэвхтэй оролцож, түүхэн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, нийгэмд таниулах ач холбогдолтой арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байна. Мөн Хархорин сумын хэмжээнд "Өндөр гэгээнийхээ өвийг дээдэлэн өнөд эгшиглэх хуураа хөглье" нэртэй нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний үеэр морин хуурч Ц.Түрэв айл өрх, албан байгууллагуудын нийт 15 морин хуурыг хөглөн, шавь нарын хамт морин хуурын аялгуугаар 		
--	--	--	--	---	--	--

					<p>Мэндчилгээ дэвшүүлж, уламжлалт урлагийг сурталчлан таниулахад хувь нэмэр орууллаа.</p> <p>“Монгол Бахархал” уриан дор зохион байгуулагдаж буй бүтээлч сарын аяны хүрээнд Монголын төр, нийгэм, шашин, соёлын нэрт зүтгэлтэн, Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын мэлхий гийсний 390 жилийн ойд зориулсан “Алтан соёмбо мину” боловсрол танин мэдэхүйн ажлыг зохион байгуулав. Танин мэдэхүйн ажлын хүрээнд Өндөр гэгээн Занабазарын намтар уран бүтээл түүнтэй холбоотой Орхоны хөндийд орших сүм хийдүүдийн талаар танилцуулга мэдээлэл өглөө. Өндөр гэгээн Занабазарын амьдрал, үйл хэргийн талаар танилцуулахын дээр түүний зохиосон Соёмбо үсгийг утгыг тайлбарлах, дүрсэлгийн онцлогийн талаар ярилцан ЕБ-ын нийт 200 гаруй сурагчидтай хамтран хэлэлцүүлгийг зохион байгуулав.</p>		
--	--	--	--	--	---	--	--

3.	<p>Арга хэмжээ 3.3. Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад хүүхэд, залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилготой эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулах</p>	<p>Сургалтанд хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо</p>	-	18	<p>Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, орон нутгийн хүүхэд залуусын оролцоо, мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газар болон Ерөнхий Боловсролын Гүнзгий сургуультай хамтран 3 сургуулийн дунд Карл Поплөрийн мэтгэлцээний аргачлалд суурилсан мэтгэлцээний зохион байгуулгаа. Мэтгэлцээн нь нийт 6 сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд сурагчдын шүүмжлэлтэй сэтгэхүй, нотолгоонд суурилсан байр сууриа илэрхийлэх чадвар, багаар ажиглах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэв. Үүнд, 2-р сэдэв нь "Хархорин сумын түүхэн дурсгалт газруудыг хамгаалахын тулд орон нутгийн иргэдийн эзэмшлийн эрхийг хяагаарлах нь зүйтэй эсэх" сэдвийн хүрээнд өрнөсөн бөгөөд багууд тухайн сэдвийг батлах болон няцаах хоёр талаас нотолгоо,</p>	11.27	100
----	--	--	---	----	---	-------	-----

					судалгаанд үндэслэн мэтгэлцсэн нь сурагчдын: соёлын биет өвийг хамгаалах чухлыг шинэ өнцгөөс харж, өөрсдийн оролцоогоор орон нутгийн түүхэн дурсгалт газруудыг хэрхэн хамгаалах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх боломжит шийдлүүдийг санал болгон хэлэлцсэн нь зорилгод нийцсэн үр дүнтэй ажил боллоо.		
4.	Арга хэмжээ 3.4. Аймгийн Засаг даргын 2020 оны А/238 дугаар захирамжаар баталсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах журам"-ын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах	Журмын хэрэгжилтийн хувиар	-	70	Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран "Мэлхий чулуу"-ны бохирдлыг арилгаж, мэргэжлийн түвшний сэргээн засварын ажлыг амжилттай гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд дурсгалт газрын гадаргуу дээрх бохирдол, хагарал, эвдрэл гэмтлийг нарийвчлан үнэлж, хамгаалалтын стандартын дагуу цэвэрлэгээ, бэхжүүлэлт, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах чиглэлээр нийт 42 иргэнтэй	02.01-12.01	90

					<p>Байгуулсан гурвалсан гэрээг дахин шинэчилж, гэрээний хугацааг сунган ажиглав. Энэхүү арга хэмжээ нь 2023, 2024 оны ИТХ-ын шийдвэрээр батлагдсан бодлогын хүрээнд хэрэгжиж ирсэн бөгөөд 2025 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа юм. Харин гэрээт хамгаалагчдыг урамшуулах хөрөнгө нь энэ онд төсөвт тусгагдаагүй тул 2025 онд гэрээт хамгаалагчдад олгох урамшууллыг олгож ажиглаж чадаагүй байна. Үүний улмаас өмнөх жилүүдэд тогтмол хэрэгжүүлдэг байсан урамшууллын дэмжлэг түр хугацаагаар зогссон бөгөөд цаашид шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад мэдээлж байна.</p>		
--	--	--	--	--	---	--	--

ХОЁР МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Хүссэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	3	4			
1.	Арга хэмжээ 1. Монгол бичгийн чадварыг дээшлүүлэх сургалтанд суух	Монгол бичгийн чадварыг дээшлүүлэх	-	2		Байгууллагын албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох, Монгол бичгийн анхан шатны сургалтад 1 удаа, дунд шатны сургалтад 2 удаа хамрагдаж монгол бичгийн унших, бичих чадварыг дээшлүүлсэн.	02.01-12.01	100	
2.	Арга хэмжээ 2. Төрийн албаны цахим хуудсанд байршуулсан сургалтанд хамрагдах	Бие даан судлах	-	1		Төрийн албаны зөвлөлийн Surlait.gov.mn сайтad байршуулсан Дизайн сэтгэлгээ онлайн хичээлд нийт 85 минутын цахим хичээлийг бие даан судлан постер, мэдээлэл бэлтгэл хийх чадварыг дээшлүүлжээ. Төрийн албаны цахим хуудсыг И-Монголиа системтэй холбох цахим сургалтад хамрагдаж, цахим шилжилтийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлжээ.	02.03-11.01	100	

НЭМЭЛТ ҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

Д/д	Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэгтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэгт)			
	1	2	3	4	5	6	7	
1	Сумын цахим хуудас хөгжүүлэх	Мэдээлэл цуглуулах	2019 онд зохион байгуулсан	Нийгмийн сүлжээгээр нийтэлсэн байна	http://kharkhotin.ov.gov.mn/ сайтad нийт 155 удаагийн мэдээ, 6 цэсний 200 гаруй мэдээлэл, Засаг даргын 2024, 2025 оны захирамж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, ажил байдлын тодорхойлолт зэргийг оюунардан байршуулж, нүүр хуудасны 6 бүлгийг нэгтгэн хөгжүүлэлттүүдийг хийж гүйцэтгэж байна.	02.05-12.01	100	
2	2025 оны цэргийн шинэчилсэн бүртгэл	Мэдээлэл цуглуулах	-	3	Сумын 2025 онд цэргийн жинхэнэ албанд татагдаж болох залуучуудын урьдчилсан болгож (Маягт 14) -ийг Багийн Засаг дарга нараас авч бүртгэн нийлүүлсэн. Сумын ангийн бууны нэгдсэн мэдээ (Маягт 13)-ийг Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэсийн галт зэвсэг хариуцсан Бат-Эрдэнэ	01.14-01.21	100	

					Цагдаагаас авч мөн нэгтгэн авч нийлүүлсэн. Сум багийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй авто техник, хэрэгсэл, өөрөө явалч механизмдын судалгаа (Маягт 11)-ийг Багийн Засаг дарга нараас авч бүртгэн нийлүүлсэн.		
3	Багуудын иргэдийн нийтийн ажлын хэсэгт ажиглах	-	-	6	Багуудын иргэдийн нийтийн хурлын ажлын хэсэгт ажигласан. Ганган орхон баг, Нарийн хур баг, Онгоцон ухаа баг, Жалбаа баг, Шанх баг, Орхон багуудын Багийн Засаг дарга сонгох сонгуулийн ажиглалт дараа сонгох сонгуулийн ажиглалт техник хэрэгсэл, хурлын тэмдэглэл бичих, иргэдийн ирц бүртгэл, тооллогын комиссын ажлуудыг 02 сарын 02-оос 07-нийг хүртэл хийж гүйцэтгэсэн.	02.02-02.07	100
4	Аялал жуулчлалын салбарын нэгдсэн зөвлөгөөнд оролцох.	Мэдээлэл цуглуулах	-	1	Арвайхээр суманд зохион байгуулагдсан аймгийн аялал жуулчлалын салбарын нэгдсэн зөвлөгөөнд оролцсон. Уг зөвлөгөөнөөр Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх эвент арга хэмжээ, Аялал жуулчлалын биенес эрхлэгчдийг дэмжих бодлого,	03.27	100

					Орон нутгийн Аялал жуулчлалын өгөөжийг нэмэгдүүлэх хүчин зүйлс, Нутгийн иргэдэд түшиглэсэн Аялал жуулчлалыг хөгжүүлэх, Орон нутгийн Аялал жуулчлалын брэндийг бий болгох хөгжүүлэх сэдвүүдээр зөвлөгөө өгч Торгоны зам эвэнт арга хэмжээг зохион байгуулах талаар хуралдлаа.		
5	Тусгаар тогтнол 3333 арга хэмжээг Хархорин суманд зохион байгуулах.	Арга хэмжээ	-	1	Улаанбаатар хотын Оюуны ундраа сургуулийн 29 сурагч Хархорин сумын Эрдэнэзуу хийд дээр Орхон сургуулийн сурагчидтай нийлэн нийт 104 сурагч Тусгаар тогтнол шүлгийг уншсан. Мөн Хархорин сумын Онцгой байдлын газар, Эрдэнэ зуу музей, Хархорум музейтэй танилцаж Соёлын төвд урлагийн номеруудаар үзүүлбэр үзүүлсэн. Уг үйл ажиллагааг Орхон сургууль, Оюуны ундраа сургуулийн багш нар, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нартай хамтран амжилттай зохион байгуулсан.	04.03- 04.04	100
6	Хүүхдийн хөдөлгөөнт гимнастик үйл	Арга хэмжээ	Жил бүр	1	Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан Хөдөлгөөнт гимнастикийн	05.13	100

	ажиллагаанд оролцох				зохиомол, заавал сурах 2 төрөлт тэмцээнд 5 цэцэрлэгийн 120 гаруй хүүхдүүд оролцож, тэмцээнийг шүүн явуулж амжилттай зохион байгуулсан.		
7	6 дугаар сарын 1-ний үйл ажиллагааны талаарх ажлын хэсэгт орж зохион байгуулах ажлыг хэлэлцэж төлөвлөгөөг хамтран гаргалаа.	Арга хэмжээ	Жил бүр	1	Эх үрсийн баярын ажил хэсэгт оролцон нийт 34 хүний бүрэлдэхүүнтэй 8 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Үүнээс дугуйн уралдааны 9-11 насны 62 хүүхдийн бүртгэлийг хийж гүйцэтгэж, уралдааны нийт хүүхдүүдийг гараанаас гаргах ажлыг хариуцан авч амжилттай зохион байгуулсан.	06.01	100
8	Байгууллагын Эх үрсийн баярын үйл ажиллагаанд оролцох	Арга хэмжээ	Жил бүр	1	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн санаачилсан жил бүр уламжлал болгон явагддаг арга хэмжээ бөгөөд үйл ажиллагааг зохион байгуулан, хөтлөн явуулсан.	05.31	100
9	Эхийн алдар одон гардуулах үйл ажиллагаанд оролцох	Арга хэмжээ	Жил бүр	1	Эхийн алдар одон гардуулах үйл ажиллагааны ажлын хэсэгт оролцон нийт 84 эхийн одон гардуулах ажлын зохион байгуулан шагналыг байршуулан, зөөж, постер зургийг бэлтгэн, хийж гүйцэтгэсэн.	05.30	100

10	"Хангай хайрханы тахилга"-ийг зохион байгуулах	Арга хэмжээ	Жил бүр	1	Хангай хайрханы тахилгын эх бэлтгэж олон нийтэд түгээх, хөтөлбөр гаргах зэрэг бэлтгэл болон зохион байгуулалтын ажлыг мэргэжилтнүүдтэй холбогдох хамтран хийж, гүйцэтгэв.	06.04	100
11	Байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл бэлдэж, олон нийтэд хүргэх	Мэдээний тоо	-	-	Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, сурталчлах зорилгоор нийт 52 удаагийн постер бэлдэж "Хархорин мэдээ" нийгмийн сүлжээгээр нийтэлсэн.	01.01-12.01	100
12	"STAY IN КНАРКНОРИН" төсөл	Төлөвлөгөө	2025 оноос санаачилсан	1	Хархорин сумын Нутгийн зөвлөлгөөс санаачилсан "Stay In Knapkhorin" төсөл нь Хархорин сумын жуулчдын хоноглох хугацааг уртасгах, жуулчдыг татах зорилготой төсөл бөгөөд одоогоор 12 хүний бүрэлдэхүүнтэй эхэлжэж байгаа бөгөөд Фэйсбүүк хуудас нээж хөгжүүлэлт явагдаж байна.	04.29-12.01	100
13	Археологийн хайгуул судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх	Тайлан ирүүлэх	-	1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/107 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Талеонтологи, археологийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах	07.10-10.01	100

					журал"-ын 3.1.1. дэх заалтыг үндэслэсэн Өвөрхангай даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Шийлэгцэрэн даргын албан тоотын дагуу Өвөрхангай аймагт малтлага судалгаа хийж байгаа газруудаар 08 сарын 05-нд Хархорин сумын Баянголын аманд хийгдэж буй малтлага дээр хяналт хийж, тайланг хүргүүлэв.		
14	Монгол улсад хүүхдийн хөдөлгөөн, байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан хамтарч ажиглах.	Арга хэмжээ	-	1	2024-2025 оны хичээлийн жилд улсын олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож шагналт байрт шагналт байрт шалгарсан сурагчдийн мэдээллийг бүртгэн авч нийт 52 анкет ирснээс шалгаруулан 28 сурагчийг Засаг даргын Өргөмжлөл шагналыг гардуулсан.	06.06	100
15	Хархорин Сагсны лигт оролцох	-	2025 оноос	1	Хархорин Засаг даргын Тамгын газрыг төлөөлөн нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 сарын турш 9 тойрог тоглож, амжилттай оролцон Хүрэл медалийг хүртсэн.	03.30-05.22	100
16	ИНХ-ийн тэмдэглэл хөглөх	Арга хэмжээ	Жил бүр		Жалбаа багийн ИНХ-ийн тэмдэглэлийг 2025 оны 06 сарын	06.20	100

					20-ний өдөр багийн төвд хөтлөн явуулж ирц бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.		
17	Хархорум хотын их бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээнд оролцох	Арга хэмжээ	-	1	2025.06.15-ны өдөр 11:00 цагт Хархорум хотын их бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээ "Их хаадын цэцэрлэгт хүрээлэн"-д Монгол улсын төрийн далбаа мандуулах ёслолд оролцлоо.	06.15	100
18	Цолны мялаалга наадмыг хамтран зохион байгуулах	Арга хэмжээ	-	1	Ардын хувьсгалын 104 жилийн ой, Хархорин сумын 69 жилийн баяр наадмын хүрээнд улс, аймаг, сумын цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэх "Цолны мялаалга" наадам зохион байгуулж хамтран ажиглаа. Нийт Хархорин мэдээнд 12 удаагийн постер мэдээлэл бүхий зургийг байршуулсан байна.	08.22	100
19	Судалгаа хүргүүлэх	Тайлан ирүүлэх	-	1	Хархорум хотын захирагчийн албанаас ирүүлсэн мэдээлэл ирүүлэх албан бичгийн хүрээнд "Хархорум орчимд аялал жуулчлалын үйл ажиглагаа эрхэлж буй ААН-үүдийн тоо" болон "Хархорум орчимд аялж буй гадаадын жуулчдын тоо /Сүүлийн 5 жил/, хэтийн төлөв" гэсэн статистик мэдээлэл,	09.10	100


					судалгааг Хархорум хотын захирагчийн ажлын албаны хөрөнгө оруулалт харуцсан мэргэжилтэн Б.Түвшингэрэлд цахимаар хүлээлгэн өгөв.			
20	Архивын үлсэгийн үзлэгийн ажлыг ханган ажиглах	улсын бэлтгэл ханган	-	-	1	Архивын үлсэгийн үзлэгийн бэлтгэл ажлыг ханган ажиглаж, албан бичгүүдийг цэгцлэх, дугаарлах тооллогын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.	09.17-19	100
21	Хархоринь намар- Үзэсгэлэн худалдаа 2025	Арга хэмжээ	Жил бүр	1	Хархоринь намар- Үзэсгэлэн худалдаа 2025 арга хэмжээний ажлын хэсэгт оролцон, иргэдэд мэдээлэл өгөх постер зургийг хийж, үйл ажиглалгааг хөтгөн явуулж, бүртгэл мэдээллийг хийж гүйцэтгэж, иргэдийг идэвхжүүлэх хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдааныг зохион байгуулж ажиглалаа.	09.25-26	100	
22	Пэйж хөгжүүлэх хуудас	2026	-	1	Хархоринь сумын 70 жилийн ойн албан ёсны пэйж хуудсыг нээн ажиглуулж, агуулгын хөгжүүлэлт болон танилцуулгын контент бэлтгэх ажлыг үргэлжлүүлэн хийж байна.	10.01	100	
23	ИТХ-ын ээлжит 6-р хуралд танилцуулах	Тайлан	-	1	ИТХ-н 16/07 дугаар тогтоол Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөны 2023, 2024 оны	10.24	100	

					хэрэгжилт, үр дүнгийн тухай ИТ-ын 6-р хуралд тайлагнав.		
24	Шашны байгууллагад хяналт, шалгалт хийх	Арга хэмжээ	-	1	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уламжлалт бус шашны байгууллагад хяналт шалгалт хийж үйл ажиллагаатай танилцлаа.	11.20	100
25	Видео контент засварлах	-	-	8	Тус ажлын хүрээнд Хархорин мэдээ фэйсбүүк цахим сүлжээнд арга хэмжээ болон тайлант ажлуудыг танилцуулах зорилготой 8 удаагийн видео бичлэг, рийлүүдийг засварлан байршуулсан байна.	11.28	100
26	Салбарын шагналыг холбогдох газарт хүргүүлэх	-	Жил бүр	6	Тэргүүний барилгачин цол тэмдгээр - 6 Тээврийн тэргүүн -16 Авто тээврийн тэргүүний ажиглан одон медалиар -12 Санхүүгийн тэргүүний ажиглан цол тэмдгээр -4 Тус тус шагналд тодорхойлуулсан нийт 38 иргэний анкетийг холбогдох байгууллагуудад журмын дагуу хүргүүлэв.	02.01-12.01	100
27	Ice Karakorum festival-2025 -д оролцох	-	Жил бүр	1	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг арга	12.06-07	100

					Хэмжээнд оролцохоор орон нутгийн онцлогийг харуулсан гэрийг тохижуулах, нүүдэлчдийн өвлийн хувцасны үзүүлбэр үзүүлэх, сумын худалдаа эрхлэгчдийг татан оролцуулах зэрэг ажлын бэлтгэл хийгдэж байна.		
28	2025 оны Жилийн эцсийн Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын комисст орж ажиглах	-	Жил бүр	1	2025 оны Жилийн эцсийн Мал тооллогод Жалбаа багийн урд хэсэгт хуваарьлагдан зохион байгуулах ажлын хүрээнд малын тоог задлах, системд шивэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.	12.07-12.10	100
29	Хархорин сумын оны шилдэг шалгаруулах ажлыг зохион байгуулж, хайтран ажиглах	-	Жил бүр	1	Хархорин сумын оны шилдэг шалгаруулах ажлын хүрээнд постер зураг бэлтгэх, оролцогчдын анкетийг бүртгэж архивлах, баярын үйл ажиллагааны үеэр танилцуулга шалгаруулалтын ппт бэлтгэнэ.	12.30	100
30	Сумын Шинэ жил зохион байгуулах ажлыг хамтран зохион байгуулах	-	Жил бүр	1	Сумын Шинэ жил зохион байгуулах ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хийх, шагнал урамшууллыг бэлтгэн, гардуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.	12.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

СОЁЛ, АЯЛАГ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.НАРАНГЭРЭЛ



2025:12:03